

СУАР-Д ХЯТАДЫН УДИРДЛАГААС СҮҮЛИЙН ҮЕД ЯВУУЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

М. Хурметхан

Синьцзяны олон угсаатан ард түмний шаргуу хөдөлмөр, ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжийн ачаар нэг үе их амжилт олж байсан Снцзьян-Уйгурын автономит районы хөдөө аж ахуй, аж үйлдвэр маогийнхны явуулсан удаа дараагийн улс төрийн адал балмад кампанийн уршгаар уналтын байдалд орсон билээ.

Сүүлийн жилүүдэд ч гэсэн СУАР-ы эдийн засгийн байдал бүхэлдээ сайжраагүй хэвээр байна. Ийм нөхцөлд хятадын эрх баригчид нийт улс орныхоо нэг адил тус автономит районы эдийн засгийн хоцрогдлыг арилгаж, түүнийг шинэчлэн өөрчилж, тэнд «дөрвөн шинэчлэлт»-ийг тууштай хэрэгжүүлэхийг уриалсаар байна. 1979 оноос хойш хятадын эрх баригчид эдийн засгийн бодлогодоо зарим нэг өөрчлөлт оруулан, урьд мөрдөж байсан зарим баримтлалаасаа арга буюу татгалзахад хүрчээ. СУАР-ыг хятадын бусад муж, автономит районтай харьцуулахад түүний эдийн засгийн хөгжил нь нэлээд дорой хэвээр байна. Үүнийг СУАР-ы намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ван Эньмао «1966-1976 онд манай эдийн засаг маш их сүйрсэн юм»¹ гэж хэлсэн зүйл гэрчилж байна. Тус районы өөр нэг эрх баригч Исмайл Аймаг «Улаан туг» сэтгүүлд бичихдээ, «манай орны (СУАР-ы М. Х.) аж ахуй, соёл, боловсролын бүтээн байгуулалтыг...бүх улсын тэргүүн зэргийн ах дүү муж, өөртөө засах орныхтой харьцуулахад тун их зөрөөтэй байгаа бөгөөд дөрвөн шинэчлэлтийн шаардлагаас хэт хол зөрж байна гэснийг бид сэргэгээр олж харах хэрэгтэй»² гэсэн нь энэ районы хөгжлийн түвшин асар их доогуур байгааг өөрсдөө ч хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм.

Иймд хятадын эрх баригчдын өмнө тус районы эдийн засгийн хоцрогдмол дорой байдлыг өөд татах явдал хурц асуудал болсон байна. Энэ талаар ХКН-ын XII их хурлаар 1982 оны 9-р сарын 6-нд баталсан «Хятадын коммунист намын дүрэмд» заахдаа «ХКН нь дотоодын үндэстнүүдийн тэгш эрх, эв нэгдэл, харилцан туслалцах харилцааг хамгаалан хөгжүүлэх, үндэстний цөөнхийн районуудад **эдийн засаг, соёлоо хөгжүүлэхэд туслаж, үндэстний боловсон хүчнийг идэвхтэй бэлтгэн шилж дэвшүүлнэ**»³ гэжээ.

¹ ИБАС 9 декабря 1982.

² «Улаан туг» 1982. № 9. 50-р тал.

³ «Жэньминь жибао» 1982.9.13 .

ХКН-ын XII их хурал дээр СУАР-ы намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ван Эньмао хэлсэн үгэндээ: «Синьцзяны өргөн уудам нутагт бүтээн байгуулалтыг өрнүүлэхэд гол нь Синьцзяны олон үндэстэн ард түмний **өөрийн хүчиндээ түшиглэсэн шаргуу тэмцэл чухлаас гадна улсаас санхүү, хөрөнгө, хүн хүчний тусламж авах хэрэгтэй**»⁴ гээд, «Синьцзянд социализмын шинэчлэлтийн бүтээн байгуулалтын нөхцөлийг сайжруулан хөгжүүлэхдээ хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйг хөгжүүлэх аятай нөхцөл бий болгож, мөн аж үйлдвэрийг хөгжүүлэх сайхан нөхцөл бий болгох хэрэгтэй» гэсэн байна.

Синьцзян нь **хөдөө аж ахуйн талаар** хятадын удирдагчдын бодлого, юуны өмнө хөдөө аж ахуйгаас авах бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, газар тариалангийн хувьд гол төлөв хөвөн, чихрийн манжин, ногоо, жимсний баазтай болох, мал аж ахуйн районы хувьд тэргүүний мал аж ахуйн район болох, тус районд мах, малаас гарах бусад бүтээгдэхүүнээр районыг ханган, хятадын төвийн районуудад нийлүүлдэг хэрэгцээт мал аж ахуйн бүтээгдэхүүнийг улам их болгох, усны асуудлыг шийдвэрлэн, мод өвсийг шилжүүлэн суулгаж, байгалийг хамгаалах, зохих хэмжээний атар газрыг шинээр эзэмшин, Синьцзяны хөдөө аж ахуйг техникужүүлж механикжуулах, шинжилгээ-судалгааны ажил явуулах чиглэлээр хөдөө аж ахуйг хөгжүүлнэ гэж үзэж байна.

Синьцзяны **аж үйлдвэрийн хувьд** түүний баялаг түүхий эдийг харгалзан үйлдвэрлэлээр хятадын том бааз болгох, газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах хөнгөн үйлдвэр, юуны түрүүнд хөвөн, ноос, чихрийн үйлдвэрийг голлон хөгжүүлэхийг эрмэлзэж байна.

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг хөгжүүлэх талаар тавигдаж буй дээрх зорилтыг биелүүлэхэд Синьцзяны одоо байгаа зам тээвэр шийдвэрлэж чадах боломжгүй учир уг асуудлыг хятадын эрх баригчид их анхаарч байна. Ялангуяа энэ районд хятадын төв мужууд, хотуудаас «туслах», өөрөөр хэлбэл төв хятадын районуудаас хятад хүмүүсийг нүүлгэн суурьшуулахтай шууд холбон үзэж байна. Тухайлбал, 1979 оны 5, 6-р сард Тяньцзинд болсон БНХАУ-ын Төрийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан дээр «хан үндэстний олон тооны хүн ам, түүний техникийн давуу байдлыг үндэстний цөөнхийн уудам нутаг дэвсгэр, түүний байгалийн баялагтай холбон хослуулахыг»⁵ зааж байсан бол ХКН-ын XII их хурал дээр СУАР-ы намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ван Эньмао хэлэхдээ, «хүн хүчний туслалцаа авах хэрэгтэй Синьцзяны хүн амыг гадагш явуулж болохгүйгээр үл барам хятадын нутгийн гүнээс хүн оруулах хэрэгтэй»⁶ гэжээ. Нийтдээ 13,5 сая хүн амтай (үүний тэн хагасаас илүү нь хятад хүмүүс), хятадын газар нутгийн зургааны нэгийг эзэлдэг Синьцзян нь бэлчээр, ой мод, газар доорхи байгалийн арвин их нөөцтэй юм. СУАР-ы нутагт нефть, нүүрс, ховор болон өнгөт металл, гялтагнуур, бал чулуу, уран, зэс төмрийн хүдэр зэрэг асар их хэмжээний ашигт малтмал байдаг бөгөөд Синьцзяны нефтийн нөөц нь Ираныхаас даруй 16 дахин их, нүүрс 1000 млрд тонн, төмрийн хүдрийн нөөц 400 сая тонн юм.⁷

⁴ «Жэньминь жибао». 1982.9.10.

⁵ АРВМ КНР. М, 1980, С—142.

⁶ «Жэньминь жибао». 1982.9.10.

⁷ «Чайна Дейли». 1983.6.17.

Дээрх «холбон хослуулах» «нутгийн гүнээс хүн ирүүлэх» бодлогынхоо дагуу хятадын эрх баригчид эдийн засгийн хувьд харьцангуй хөгжилтэй томоохон хот, мужуудыг Синьцзянтай эдийн засаг-техникийн талаар хамтран ажиллуулахыг чухалчилж байна. 1979 оноос хойш үндэстний бусад районы нэг адил СУАР-д төв мужуудтай хамтарсан үйлдвэрийн газрууд байгуулан, түүний байгалийн баялагийг бусад муж, хотын хэрэгцээнд ашиглаж эхлэв.

1983 оны хавар гэхэд СУАР-тай төв хятадын 6 муж, хоттой «хамтран ажиллах» 126 гэрээнд гарын үсэг зурсан юм. Энэ нь бусад хөгжингүй газруудын технологийн тусламжтай Синьцзяны баялаг нөөцийг олборлон ашиглах замаар энэхүү «стратегийн хувьд чухал хилийн районыг хөгжүүлэх хүчин чармайлтын нэг хэсэг»⁸ гэж хятадын хэвлэлд бичжээ. Мөн Синьцзянд хятадын төв мужуудаас хүн оруулах бодлого нь сүүлийн жилүүдэд нэлээд өвөрмөц шинжтэй болов. Урьд нь дан хятад хүмүүсийг нүүлгэн ирүүлдэг байсан бол одоо үйлдвэрийн газруудтай нь нүүлгэн ирүүлж байна. Сүүлийн гурван жилд хятадын төвийн мужуудаас олон зуун мянган хятад залуучуудыг энд нүүлгэн ирүүлснээс гадна хэд хэдэн үйлдвэрийн газрыг ажилчдын хамтаар Шанхай, Ланьжоу зэрэг хотуудаас нүүлгэн Синьцзяны Урумч, Шихэзы зэрэг хотуудад байрлуулан суурьшуулав. Хэрэв хятадын удирдагчид СУАР-д хөдөө аж ахуй, аж үйлдвэр болон бусад салбарыг тус районы уугуул ард түмний эрх ашигт бүрэн нийцүүлэн хөгжүүлж байгаа бол зүйн хэрэг юм. Гэтэл хятадын удирдлагын бодлогын бодит зорилго тийм биш байна. Хятадын эрх баригчид СУАР-д түүний байгалийн ашигт малтмалыг ашиглах үүднээс олборлох үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэрүүдийг нийт хятадын хэрэгцээнд зориулан хөгжүүлж байгаа нь Синьцзяныг үнэндээ хятадын газар тариалангийн хавсарга район хэвээр үлдээж байна. Ялангуяа СУАР-ы байгалийн ашигт малтмалын арвин нөөцөд түшиглэн, тус районд пуужин-цөмийн зэвсгийн үйлдвэр байгуулан, түүний туршилтын талбар болгож, уул зэвсгийг байрлуулж байгаа нь СУАР-ы олон угсаатан ард түмний амин чухал эрх ашгаар үл барам түүнтэй хөрш улс орнуудын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж байгаа зүйл юм.

Хятадын эрх баригчид СУАР-ы аж үйлдвэрийг цэргийн хэрэгцээнд зориулж байгаа нь түүний иргэний салбарын хөгжлийг зогсонги байдалд хүргэсэн явдал ч бас ажиглагдаж байна. Үүнийг нэхмэл, хүнс, цаас, хөдөө аж ахуйн машин, трактор, бордооны үйлдвэрийн хүчин чадал нь сүүлийн 20 гаруй жилийн турш бараг нэмэгдээгүй явдал гэрчилж байна. СУАР-ы аж үйлдвэрийн бааз, түүхий эдийн их нөөцийг цэргийн аж үйлдвэрт, юуны өмнө пуужинт цөмийн программыг хэрэгжүүлэхэд л тэд ашиглаж байна.

Хятадаас хөрөнгөтөн орнуудтай эдийн засгийн талаар харилцах «нээлттэй хаалгын» бодлогын дагуу СУАР-д гадаадын капитал нэвтэрч байна. СУАР-д АНУ, Япон, ХБНГУ, Итали, Австрали зэрэг орон, мөн Гонконгийн хөрөнгөтнүүдтэй хамтран 100 сая америк долларын хөрөнгө оруулалттай 22 объектийг барихаар хэлэлцээ хийжээ.⁹ Эдгээр нь тус районы байгалийн нөөцийг олборлох, өнгөт ба ховор металл, нэхмэл эдлэл, малын тэжээл үйлдвэрлэх зэрэг чиглэл бүхий үйлдвэрүүд юм. Түүнчлэн нефть, нүүрс, хүнсний давс боловсруулах үйлдвэр

⁸ «Чайна Дейли» 1983.XI.5.

⁹ «Чайна Дейли» 1983.5.20

байгуулахад гадаадын капиталыг бас татан оруулахыг зорьж байна. Ийнхүү СУАР-д гадаадын капиталыг нэвтрүүлж байгаа нь БНХАУ-ын улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд хөгжингүй хөрөнгөтөн орнуудтай хийх эдийн засгийн харилцааны хөшүүргийг идэвхтэй ашиглах гэсэн хятадын эрх баригчдын бодлогын нэг хэсэг юм.

Синьцзяны байгалийн баялагийг олборлон ашиглахад зам тээврийн байдал хоцрогдмол байгааг харгалзан ойрын жилүүдэд тус районы тойрог, хошуудыг районы төвтэй асфальт замаар холбож, цаашдаа орон нутгийн засмал замыг өргөтгөхөөр төлөвлөж байгаа ажээ.¹⁰

Тус автономит районд мэргэжилтэй боловсон хүчин, инженер-техникийн ажилтнууд ихээр дутагдаж байна. 1980 оны байдлаар хятадын үндэсний автономит районуудад уугуул ард түмний инженер-техникийн ажилтан 82700 ажиллаж байсны дээд, дунд техникийн боловсролтой нь дөнгөж 2,6 гаруй хувийг эзэлж байв.¹¹

Энэ тоо Синьцзянд бүр бага байгаа юм. 1980 оны эхээр СУАР-д дээд боловсролтой, техникийн ажилтнуудад үнэмлэх гардуулахад тус автономит районы нийт дээд боловсролтой техник ажилтан 1008 байсны уйгур, казах, монгол, хотон зэрэг хятад биш үндэстний төлөөлөгчид дөнгөж 91 хүн байв.¹² Харин дунд мэргэжилтэн, техник ажилтнуудын ихэнх нь хятад биш ард түмний төлөөлөгчид байв.

Ийм ч учраас сүүлийн жилүүдэд хятадын эрх баригчид дээд сургууль, техникийн тусгай мэргэжлийн сургууль төгссөн хятад хүмүүсийг хятадын төв мужуудаас СУАР-д олноор явуулж уугуул ард түмний тийм мэргэжлийн хүмүүсээс дээгүүр хангамжтай ажиллуулж байна.

1983 оны хоёрдугаар хагаст СУАР-д ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян нар очсон юм. Урумч хотод тэд хэлсэн үгэндээ үндэстний «нэгдэл нягтралыг» зузаатгах, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, Синьцзяны стратегийн байдлыг онцлож байв. Тухайлбал Жао Зыян «Синьцзян бол эдийн засаг болон стратегийн талаар онц гой чухал ач холбогдолтой юм»¹³ гээд, дараагийн XXI зуунд хятадын эдийн засгийн бүтээн байгуулалтад Баруун хойт хятад, ялангуяа СУАР гол үүрэг гүйцэтгэх стратегийн зорилтыг дэвшүүлэв.

Ху Яобан, Жао Зыян нар хэлсэн үгэндээ ойрын жилүүдэд Синьцзян нь мал аж ахуй, техникийн ургамал, нефтийн гол чухал бааз болох бололцоотой гээд, Синьцзяны экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, хэрэгцээт бараагаа импортлохыг дэмжиж байна гэжээ. 1983 оны 12-р сард БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс хятад биш үндэстний үйлдвэрлэл ба амжиргааны хурлыг Бээжинд хийв. Эдгээр хурлын материалыг үзэхэд Синьцзянд хүн амыг хувцас, хүнс, орон сууц, ундны ус болон хамгийн наад захын амьдралын нөхцөлөөр хангах асуудал хурц хэвээр байна.

СУАР-д хятадын эрх баригчдаас эдийн засгийн талаар явуулж буй бодлого нь үндсэндээ тус районд аж үйлвэрийн олборлох салбарыг голчлон хөгжүүлэхийн зэрэгцээ инженер-техникийн хэрэгцээт түүний боловсон хүчин бэлтгэх нэрийдлээр хятад хүмүүсийг үйлдвэрийн нь хамт нүүлгэн олноор ирүүлж ажиллуулахад чиглэж байна. Ялан-

¹⁰ ИБАС, 9 декабря 1982.

¹¹ «Миньцзу туаньцзе» 1982, № 7, 27-р тал.

¹² «Гуанмин жибао» 1983.4.16

¹³ «Чайна дели» 1983.9.4.

гуяа уг бодлогын нэг онцлог нь СУАР-ы хүн хүч, нөөц баялагийг цэрэг-дайны зорилгод сайтар ашиглаж, энэхүү хилийн районыг «хүчирхэг цайз» болгон хувиргахад чиглэж байна.

НЫНЭШНЯЯ ПОЛИТИКА КИТАЙСКОГО РУКОВОДСТВА ПО «РАЗВИТИЮ» ЭКОНОМИКИ СУАР

(Р е з ю м е)

Хотя китайское руководство в последние годы принимает ряд мер по «устранению» экономической отсталости в соответствии с задачами «4-х модернизаций» экономика СУАР по-прежнему находится на сравнительно низком уровне среди других провинций и автономных районов. Поэтому, вопрос о развитии экономики СУАР, как отмечает автор статьи, остро встает перед нынешним руководством Пекина.

В области сельского хозяйства политика китайского руководства в этом автономном районе направлена на повышение земледельческой и животноводческой продукции, делается особый упор на выращивание хлопка, сахарной свеклы, овощей, т.е. создание фруктовой базы, а развитие животноводства направлено на увеличение объема поставок животноводческой продукции центральные районы Китая.

В области промышленности, как подчеркивает автор, намечается широкая программа по освоению к 2000 году нефтяных и каменно-угольных месторождений Синьцзяна. В районе дальнейшее развитие получают энергетика и легкая промышленность в особенности.

Под предлогом «быстрого развития» Синьцзяна, по мнению автора статьи, китайское руководство переселяет в этот автономный район большое количество ханьцев из центральных районов и городов Китая вне редких случаях даже вместе с фабрично-заводским-оборудованием. Большой приток ханьцев, однако, не меняет положение экономики СУАР, который по-прежнему остается аграрно-сырьевым придатком Китая. Наоборот, приток ханьцев в СУАР усилил ассимиляцию коренного населения этого автономного района.

Наибольшую опасность для народов не только этого автономного района, но и соседних с ним стран представляют собой превращение его территории в испытательный полигон китайского ракетно-ядерного оружия, использование его богатых природных ресурсов и стратегического сырья для производства оружия массового уничтожения и др.

Автор статьи, затрагивая вопрос о проникновении в экономику СУАР иностранного капитала из-за пагубной политики китайского руководства «открытых дверей», приводит конкретные фактические данные об этом капитале.

В заключении статьи автор подчеркивает, что экономическая политика китайского руководства в СУАР ныне направлена не на действительный прогресс его коренного населения, а на превращение этого пограничного района в «мощную крепость» Китая для военной цели.